



## АУДИТЫН КОД: САГ-2018/30/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamyа@audit.gov.mn

Ахлах аудитор Р.Цолмон

Утас: 260512 Цахим хаяг: tsolmonr@audit.gov.mn

Аудитор Б.Долгоржав

Утас: 260512 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn

Гэрээт аудитор Э.Гансүх


Гэрээт аудитор Ж.Нямцэцэг

Улаанбаатар хот



**Агуулга**

<b>1</b>	<b>Хураангуй тайлан</b> .....	<b>3</b>
<b>2</b>	<b>Аудитын гэрчилгээ</b> .....	<b>10</b>
<b>3</b>	<b>Аудитын тайлан</b> .....	<b>12</b>
3.1	Оршил.....	12
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	12
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	13
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	14
3.5	Дотоод аудит.....	15
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	15
3.7	Шилэн дансны мэдээлэл .....	16
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....	16
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	17
3.9.1	Нягтлан бодох бүртгэлийн талаар: .....	17
3.9.2	Төсвийн гүйцэтгэлийн тайлагналын талаар: .....	17
3.9.3	Аудитын санал дүгнэлтийн талаар: .....	17
3.9.4	Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын талаар: .....	18
3.9.5	ТӨХК-ийн эзэмшлийн газрын тухай: .....	19
3.9.6	Хариуцлага тооцох тухай:.....	19
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	19
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд .....	20
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	20
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	20
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	21
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	21
3.16	Үр өгөөжийн тооцоолол .....	21
<b>4</b>	<b>Менежментийн захидал</b> .....	<b>22</b>
4.1	Санхүүгийн тайлагналын талаар.....	23
4.2	Зардлын талаар .....	24
4.3	Зөрчлийн нэгтгэлийн талаар .....	25
4.4	Хөрөнгийн талаар .....	26
<b>5</b>	<b>Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл</b> .....	<b>27</b>
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	27
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	28
5.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	29
5.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	30



Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын  
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	31
6	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт.....	32
7	Албан шаардлагууд .....	34

---

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД  
Д.САРАНГЭРЭЛ ТАНАА

2018.04.25 № 1045  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайланг материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bolg\_khereg\Yawsan\2018\04\25\1045\001.docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ

САНАЛ ДҮГНЭЛТ

079483

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

### 3 Аудитын тайлан

#### 3.1 Оршил

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлийн тайлагнал, үйл ажиллагаандаа холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

#### 3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага


Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 09-нөөс 2018 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Долгоржав, гэрээт аудитор Э.Гансүх, Ж.Нямцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн сайд 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 1а/1159 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

### 3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 186 байгууллага байна. Үүнд:

- Эрүүл мэндийн яам, түүний харьяа 17;
- Нийслэлийн эрүүл мэндийн газар, түүний харьяа 22;
- Аймгийн эрүүл мэндийн газар, түүний харьяа 108 байгууллага;
- Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх 17 нэгж;
- Тусгай зориулалтын шилжүүлгийн 22 байгууллага байна.

Эрүүл мэндийн сайд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар тогтоосон дор дурдсан асуудлуудын бодлого төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:


- эрүүл мэндийн салбарын бодлогын баримт бичгийг боловсруулж, эрүүл мэндтэй холбоотой хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;
- эрүүл мэндийн байгууллагын болон хүний нөөцийн хөгжлийг дэмжих, гадаад хамтын ажиллагааг эрүүл мэндийн салбарын бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан хөгжүүлэх;
- нийгмийн эрүүл мэндийн бодлогыг зохион байгуулах, зохицуулах, олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
- хүн амд хүртээмжтэй, чанартай, аюулгүй эмнэлгийн тусламж, үйлчилгээг дээшлүүлэх;
- эм, үйлдвэрлэл, эрүүл мэндийн технологийн бодлогыг зохицуулах, эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх;
- эрүүл мэндийн хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн талаар хэрэглэгчийг судалгаа, мэдээллээр хангах, эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг зохицуулах зэрэг болно.

Эрүүл мэндийн сайд дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Эрүүл мэндийн яам /цаашид ЭМЯ гэх/ тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Эрүүл мэндийн сайдын эрхлэх хүрээний асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 3 арга хэмжээ төлөвлөснөөс 97.8 хувийн биелэлттэй байна.

Төлөвлөсөн зарим арга хэмжээний биелэлтийг дараах байдлаар товчоолов. Тухайлбал,

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлийн хүрээнд 7 арга хэмжээг төлөвлөж, биелэлт 97.9 хувь;



- Нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн хүрээнд 5 арга хэмжээ төлөвлөж, биелэлт 95.6 хувь;
- Эрүүл мэндийн бодлого, удирдлагын чиглэлийн хүрээнд 3 арга хэмжээ төлөвлөж, биелэлт 100 хувьтай байна.

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

### 3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 - 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Эрүүл мэндийн яамны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.


Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 12 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2015 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт, холбогдох стандарт, шинэчлэн батлагдсан журам, заавартай нийцэхгүй байгаа тул уг баримт бичигт дараах чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна гэж үзлээ. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маяг аргачлал;
- Хөтөлбөр, арга хэмжээ, төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй уялдуулах;
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу эрүүл мэндийн салбарын онцлогт тохирсон бүртгэл хөтлөлт;
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой асуудлууд болно.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.





Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

### 3.5 Дотоод аудит

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад хэвийн гэж үнэллээ.

ЭМЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудитыг хийх чиг үүргийг гүйцэтгэж байна.

Тус газар Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтэд дотоод аудитыг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр тайлант онд аудитыг хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжийн 12 объект, төсөл хөтөлбөрийн 3 нэгж, эрүүл мэндийн 10 байгууллагад дотоод аудит хийхээр төлөвлөн хяналтыг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт №1. Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	25
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	30
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	28
4	Илрүүлсэн нийт зөрчлийн дүн (сая.төг)	448.9
5	Үүнээс: Тогтоосон төлбөрийн актын дүн (сая.төг)	102.5
6	Хүргүүлсэн албан шаардлагын дүн (сая.төг)	346.5


Эх сурвалж: ЭМЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын 2017 оны тайлан

Илэрсэн зөрчлүүдээс дурдвал зориулалт бус зарцуулалт, цалингийн сан хэтэрсэн, ХХОАТатвар буруу тооцсон, анхан шатны баримтын бүрдэл дутуу зэрэг нийтлэг зөрчил дутагдал илэрсэн бөгөөд тухай бүрт мэргэжлийн арга зүйн зөвлөгөө, зөрчил арилгах зөвлөмж өгч, акт тогтоон, албан шаардлага хүргүүлж ажилласан байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад 2017 онд хэрэгжүүлэх 4 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Дээрх хуулиар Эрүүл мэндийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээг 52.8 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 50.6 сая төгрөгийг төвлөрүүлжээ. Ийнхүү төвлөрүүлэх орлогыг 2.2 сая төгрөгөөр дутуу хэрэгжүүлсэн байна.



Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 694,714.5 сая төгрөг, үүнээс урсгал зардалд 588,259.5 сая төгрөг, хөрөнгийн зардалд 85.6 сая төгрөгийг баталсан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл нийт дүнгээрээ 97.1 хувь буюу 674,392.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Урсгал зардалд 588,261.3 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 20,807.0 сая төгрөгөөр, хөрөнгийн зардалд 86,130.9 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг нийт 484.7 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан нь тусламжаар хөрөнгө орсонтой холбоотой байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэндийн сайд, Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа нийт 165 байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Эрүүл мэндийн яам өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ;
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ;
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;
- Санхүүгийн тайлан;
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт;
- Худалдан авах ажиллагааны тайлан зэрэг болно.

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас эрүүл мэндийн салбарын байгууллагуудын шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавьж, байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв байршуулсан эсэх, гүйцэтгэх албан тушаалтнуудын үүрэг хариуцлагын нэмэгдүүлэх, мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв байршуулах, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж гарган, тус дансны мэдээлэл хариуцсан ажилтнуудад сургалтыг зохион байгуулж ажилласан байна.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд ЭМЯ-тай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

### 3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 12 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.



### 3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

#### 3.9.1 Нягтлан бодох бүртгэлийн талаар:

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчдийн санхүүгийн байдлын тайлан 16.2 сая, төсвийн гүйцэтгэлийн тайлан 14,023.6 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна. Мөн санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийв. Цаашид энэ асуудалд анхаарч ажиллах чиглэлээр зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

#### 3.9.2 Төсвийн гүйцэтгэлийн тайлагналын талаар:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн зарлага нийт дүнгээр батлагдсан төсвөөс хэтрээгүй боловч төсвийг буруу төлөвлөснөөс бүлгийн дүнгээр: эд хогшил, урсгал засвар 14.0 сая төгрөгөөр; бүлгийн доторх дүнгээр: тэтгэврийн даатгал 1,611.7 сая, гэрэл цахилгаан 173.8 сая, бичиг хэрэг 85.2 сая, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс 119.3 сая, урсгал засвар 142.1 сая төгрөг буюу нийт 2,132.1 сая төгрөгөөр тухайн батлагдсан төсвийг тус тус хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т Төсвийн ерөнхийлөн захирагч "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийж зарцуулах, дотоод хяналтыг сайжруулах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

#### 3.9.3 Аудитын санал дүгнэлтийн талаар:

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 186 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудитаар "Хязгаарлалттай" дүгнэлт авсан 14, "Сөрөг" санал дүгнэлт авсан 1 байгууллага байна. Үүнд:

"Хязгаарлалттай" дүгнэлт авсан байгууллагууд:

- Эрүүл мэндийн яам,
- Нийслэлийн Эрүүл мэндийн газар
- Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг
- Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэг
- Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлэг
- Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг
- Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төв
- Увс аймгийн Зоонозын өвчин судлалын төв
- Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Сум дундын эмнэлэг
- Өмнөговь аймгийн Цогт цэций сумын Сум дундын эмнэлэг
- Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Сум дундын эмнэлэг
- Цагаан-Уул сумын Сум дундын эмнэлэг
- "ДОХ-ын тархалтыг багасгах нь" төсөл
- "Сүрьеэгийн өвчлөлийг бууруулах нь" төсөл

"Сөрөг" санал дүгнэлт авсан байгууллага"



#### Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Сум дундын эмнэлэг

Мөн хувьчлагдсан "Оргил" рашаан сувилал ТӨХК санхүүгийн хаалтын тайлан гаргаагүй, аудитад хамрагдаагүй, нийслэлийн харьяа өрхийн эмнэлгүүдэд улсын төсвөөс олгосон санхүүжилт болон санхүүгийн тайланг аудитад хамруулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д "... санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан ... албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэсэн заалтыг үндэслэн "Хязгаарлалттай", "Сөрөг" аудитын дүгнэлт авсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

#### 3.9.4 Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын талаар:

- 2017 онд ЭМЯ-ны хөрөнгө оруулалтын техник хяналтын зардлын данснаас анхан шатны бүрдэл дутуу баримтаар 15.0 сая, зориулалт бус 6.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Техник хяналтын зардлыг анхан шатны баримтад тулгуурлан зориулалтын дагуу зарцуулан ажиллаж, зөрчил арилгуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

- Хөрөнгө оруулалтын техник хяналтын болон чанарын баталгааны барьцааны дансны өглөгийн үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, алдаа зөрчлийг давтахгүй ажиллаж зөрчлийг арилгах албан шаардлага өгөх

- Эрүүл мэндийн яам 2017 оны хөрөнгө оруулалтаар хийгдсэн 60,823.2 сая төгрөгийн хөрөнгүүдийг ангилал буруу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дахь заалт, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын 6-р зүйлийн 6.1-д заасан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламжийг барьж дуусах хүртэл, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр захиалагч байгууллага эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайландаа тусгана. Их засварыг захиалагч байгууллага нь хөрөнгийн дүн, засварын төрлөөр тодруулга тайланд тусгана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн үйлдлийн өгөхөөр шийдвэрлэв.



- Эрүүл мэндийн сайдын 2017 онд батлагдсан төсвөөс хөдөө орон нутагт эрх шилжүүлэн олгосон 13,472.1 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн дансаар дамжуулаагүй нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын 4-р зүйлийн 4.26-д "Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад батлагдсан, эрх шилжүүлж аймаг, нийслэл, сум, дүүрэг худалдан авах ажиллагааг нь зохион байгуулсан Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалт, их засварын дансаар дамжиж санхүүжилт нь хийгдэнэ" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Энэ нь санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.26-д заасан заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Сангийн яаманд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 3.9.5 ТӨХК-ийн эзэмшлийн газрын тухай:

Монгол-Солонгосын дорно дахины анагаах ухааны төвийн 105.6 сая төгрөгийн өртөгтэй өргөтгөлийн барилгыг "Оргил рашаан сувилал" ТӨХК-ийн эзэмшлийн газар дээр 2001 онд барьж, ашиглалтад оруулсан боловч газрын зөвшөөрөлгүйгээс өөрийн эзэмшилд аваагүй, тайлан балансад тусгаагүй байна. "Оргил рашаан сувилал" ТӨХК-ийг 2017 онд хувьчлахдаа дээрх өргөтгөлийн барилгын газрыг хувьчлах газраас тусгаарлаагүй хамт шилжүүлсэн байна. Тус төвөөс газрын асуудлыг ЭМЯ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Нийслэлийн Газрын албанд удаа дараа хандсан ч асуудлыг шийдвэрлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Тус төвийн газрын асуудлыг шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.


### 3.9.6 Хариуцлага тооцох тухай:

2017 онд ЭМЯ-ны тооцооны нягтлан бодогч, төрийн сангийн ахлах мэргэжилтэн нар цаг хугацаанд нь үүрэгт ажлаа бүрэн гүйцэтгээгүйгээс тайлан зөрүүтэй тайлагнагдсан, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж бэлтгээгүй мөн шаардлагатай материал мэдээг өгөөгүй зэрэг нь санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэхэд удаа дараа хүндрэл учруулж байлаа. Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Төрийн аудитын байгууллага, түүний ажилтнууд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах аливаа мэдээллийг бүрэн хэмжээгээр, чөлөөтэй, шуурхай авах эрхтэй. Энэ хуулийн 15.1-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь саадгүй гаргаж өгөх үүрэгтэй", 21.2-т "Төрийн аудитын байгууллагын ажилтнууд аудитын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, холбогдох бусад баримт бичгийг шалгагдагч байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулж авах эрхтэй" гэсэн заалтыг зөрчсөн.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн дагуу хариуцлага тооцуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

### 3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Эрүүл мэндийн сайдын нэмэлт санхүүжилтийн дансны хөрөнгийг хоол, цайны зардалд үр ашиггүйгээр зарцуулсан, эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн буюу магадлан итгэмжлэлийн үйлчилгээний орлогыг Эрүүл мэндийн хөгжлийн төв болон эрүүл мэндийн яамны дансанд төвлөрүүлсэн, эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалт, түүнд тавих хяналт сул, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв, дүүргүүдийн өрхийн эрүүл мэндийн төвүүд 2017 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй, нэгтгэгдээгүй байгаа нь анхаарал татахуйц байна.



### 3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд дараах чиглэлээр нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагаа;
- Хөрөнгө оруулалтын зардлын дансны зарцуулалт, барьцаа дансны үлдэгдэл зэргийг 2018 оны санхүүгийн тайлангийн аудитад хамруулах,
- Өрхийн эмнэлгүүдийг аудитад хамруулсан байдлыг үзэх болно.

### 3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар системийн хэмжээнд нийт 40,428.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг нэгтгэж, баталгаажуулав.

Үүнээс, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон энэ хүрээнд түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 79,957.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс аудитаар нягтлан бодох бүртгэлийн 74,863.0 сая төгрөгийн алдааг залруулж, 2,948.7 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгч, 2,146.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 3 зөвлөмж хүргүүлжээ.


Нэгтгэлд хамрагдсан харьяа 186 байгууллага, аж ахуйн нэгж, төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 40,328.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс аудитаар 30,749.0 сая төгрөгийн алдааг залруулж, санхүүгийн тайланг засуулснаас гадна 187.5 сая төгрөгийн зөрчлийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр 58 төлбөрийн акт тогтоож, 5,125.2 сая төгрөгийн зөрчилд 56 албан шаардлага өгч, 4,266.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 242 зөвлөмж хүргүүлсэн байна.

### 3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар:

- илэрсэн нийт алдаа зөрчлөөс залруулагдаагүй алдаа зөрчил нь материаллаг байдлын тогтоосон түвшингөөс 15,398.5 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн;
- тусламжаар ирсэн хөрөнгийг бүртгээгүй, орлогыг буруу тайлагнасан, зориулалт бус зарцуулалт гаргасан;
- салбарын онцлогт тохирсон нэгдсэн Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиггүй байгаад зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийн талаар хариу ирүүлээгүй байна.

Тус сайдын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар биелэлтийг тооцож үзэхэд дээрх зөрчил давтагдсаар байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.10-т "Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрхийг "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлэхгүй байна. Иймд Монгол улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын ага байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.3-д заасны дагуу дээрх зөрчлийг ариллуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.



### 3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 752,287.4 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 15,045.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

### 3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого бүртгэл хөтлөлт, програм хангамж дотоод аудитын систем тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 3.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

### 3.16 Үр өгөөжийн тооцоолол

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 13,598.8 сая төгрөгийн үр өгөөжийн тооцооллыг хийж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлагаар баталгаажуулсан болно.



#### 4 Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ЭМЯ-ны Санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын газар болон Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.



<b>4.1 Санхүүгийн тайлагналын талаар</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №1</b>
--	----------------------------------

**ҮАГ-ын ажиглалт:**

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчдийн санхүүгийн байдлын тайлан 16.2 сая, төсвийн гүйцэтгэлийн тайлан 14,023.6 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь санхүүгийн тайлангийн аудитын “Үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

**Эрсдэлүүд:**

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

**ҮАГ-ын зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Төсвийн захирагчийн хариу:**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



#### 4.2 Зардлын талаар

#### Тэргүүлэх ач холбогдол №2

##### ҮАГ-ын ажиглалт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн зарлага нийт дүнгээр батлагдсан төсвөөс хэтрээгүй боловч төсвийг буруу төлөвлөснөөс бүлгийн дүнгээр: эд хогшил, урсгал засвар 14.0 сая төгрөгөөр; бүлгийн доторх дүнгээр: тэтгэврийн даатгал 1,611.7 сая, гэрэл цахилгаан 173.8 сая, бичиг хэрэг 85.2 сая, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс 119.3 сая, урсгал засвар 142.1 сая төгрөг буюу нийт 2,132.1 сая төгрөгөөр тухайн батлагдсан төсвийг тус тус хэтрүүлсэн нь төсвийг буруу, бодит бус төлөвлөсөн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн аудитын "Толилуулга ба тодруулга" батламж мэдэгдэлтэй нийцээгүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т Төсвийн ерөнхийлөн захирагч "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэсэн заалтуудыг хангахгүй байна.

##### ҮАГ-ын зөвлөмж:

Уг зөрчил арилахгүй, давтагдаж байгаа тул Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах, мөн дотоод аудитыг санхүүгийн хяналтыг сайжруулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

##### Эрсдэлүүд:

Үргүй зардал гаргах, санхүүгийн сахилга бат алдагдах.

##### Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

**4.3 Зөрчлийн нэгтгэлийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №3**

**ҮАГ-ын ажиглалт:**

Эрүүл мэндийн яам нь 2017 оны хөрөнгө оруулалтаар хийгдсэн 60,823.2 сая төгрөгийн хөрөнгүүдийг ангилал буруу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дахь заалт, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын 6-р зүйлийн 6.1-д заасан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламжийг барьж дуусах хүртэл, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр захиалагч байгууллага эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайландаа тусгана. Их засварыг захиалагч байгууллага нь хөрөнгийн дүн, засварын төрлөөр тодруулга тайланд тусгана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**ҮАГ-ын зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө.", Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын 6-р зүйлийн 6.1-д заасан заалтуудыг тус тус мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Эрсдэлүүд:**

Үндсэн хөрөнгө шамшигдах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

**Төсвийн захирагчийн хариу:**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



**4.4 Хөрөнгийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №4**

**ҮАГ-ын ажиглалт:**

Монгол-Солонгосын дорно дахины анагаах ухааны төвийн 105.6 сая төгрөгийн өртөгтэй өргөтгөлийн барилгыг "Оргил рашаан сувилал" ТӨХК-ийн эзэмшлийн газар дээр 2001 онд барьж, ашиглалтад оруулсан боловч газрын зөвшөөрөлгүйгээс өөрийн эзэмшилд аваагүй, тайлан балансад тусгаагүй байна. "Оргил рашаан сувилал" ТӨХК-ийг 2017 онд хувьчлахдаа дээрх өргөтгөлийн барилгын газрыг хувьчлах газраас тусгаарлаагүй хамт шилжүүлсэн байна. Тус төвөөс газрын асуудлыг ЭМЯ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Нийслэлийн Газрын албанд удаа дараа хандсан ч асуудлыг шийдвэрлээгүй байна.

**ҮАГ-ын зөвлөмж:**

Тус төвийн газрын асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Нийслэлийн Газрын албатай хамтран асуудлыг шийдвэрлэх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Эрсдэлүүд:**

Санхүүгийн тайланд хөрөнгө буруу илэрхийлэгдэх, хөрөнгө шамшигдах;

**Төсвийн захирагчийн хариу:**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

## 5 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 5.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	/мян.төг/
		Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	139,778,453.21	171,379,669.53
Мөнгөн хөрөнгө	8,243,526.00	9,950,565.53
Авлага	3,176,664.33	5,859,278.65
Урьдчилгаа	19,274,635.80	19,772,284.74
Бараа материал	108,304,118.33	135,540,675.37
Нөөцийн бараа	779,508.74	256,865.24
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	537,788,039.71	524,691,318.38
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	537,788,039.71	524,691,318.38
Биет хөрөнгө	537,032,286.29	524,065,294.99
Биет бус хөрөнгө	755,753.42	626,023.38
Бусад хөрөнгө	0.00	0.00
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	677,566,492.91	696,070,987.91
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	3,777,398.45	2,263,512.22
Богино хугацаат өр төлбөр	3,777,398.45	2,263,512.22
Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	673,789,094.46	693,807,475.69
Засгийн газрын хувь оролцоо	673,789,094.46	693,807,475.69
Засгийн газрын оруулсан капитал	307,143,779.92	313,483,879.09
Хуримтлагдсан үр дүн	208,208,831.20	231,240,077.85
Өмнөх үеийн үр дүн	80,441,875.23	206,135,883.36
Тайлант үеийн үр дүн	127,766,955.97	25,104,194.50
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	150,331,290.79	148,781,695.64
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	677,566,492.91	696,070,987.91

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## 5.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

	/мян.төг/	
ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>806,756,111.15</b>	<b>808,267,108.42</b>
ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
Бусад татвар, төлбөр, хураамж	0.00	0.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	158,461,394.44	162,592,440.54
Нийтлэг татварын бус орлого	88,463,769.16	120,001,319.89
Хөрөнгийн орлого	0.00	0.00
Тусламжийн орлого	69,997,625.28	42,591,120.65
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	0.00
Зээлийн орлого	0.00	0.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>648,294,716.71</b>	<b>645,674,667.89</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>677,462,198.36</b>	<b>777,924,253.88</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	635,330,445.77	687,638,713.46
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	497,662,395.36	538,916,971.88
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,919,312.64	219,946,441.35
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,544,885.05	23,883,134.87
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,374,540.79	27,903,835.22
Хангамж, бараа материалын зардал	10,837,681.12	12,199,110.28
Нормативт зардал	114,332,174.73	152,084,243.83
Эд хогшил, урсгал засварын зардал	4,012,846.79	4,680,922.64
Томилолт, зочны зардал	1,423,739.10	2,344,447.67
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,815,708.38	7,131,569.21
Бараа үйлчилгээний бусад зардал	91,401,506.76	88,743,266.82
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	137,648,320.05	148,721,741.58
Засгийн газрын урсгал шилжүүлэг	106,358,800.15	109,058,783.20
Бусад урсгал шилжүүлэг	27,935,205.72	35,220,356.64
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,354,314.19	4,442,601.75
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	0.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42,131,752.59	90,285,540.41
Дотоод эх үүсвэрээр	42,131,752.59	90,285,540.41
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	129,293,912.80	30,342,854.55
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	649,342.24	733,483.15
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,176,299.07	5,972,143.20
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-1,526,956.82	-5,238,660.05
<b>НИЙТ ҮР ДҮН</b>	<b>127,766,955.60</b>	<b>25,104,194.49</b>



### 5.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/ өмч
<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	574,042,965.48		574,042,965.48
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-26,659,864.31		-26,659,864.31
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	547,383,101.17		547,383,101.17
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,360,962.68		-1,360,962.68
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00		0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00		0.00
Тайлант үеийн үр дүн	127,766,955.97		127,766,955.97
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>673,789,094.46</b>		<b>673,789,094.46</b>
<b>2017 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>673,789,094.46</b>		<b>673,789,094.46</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-3,536,218.12		-3,536,218.12
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	670,252,289.40		670,252,289.40
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,549,595.15		-1,549,595.15
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00		0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00		0.00
Тайлант үеийн үр дүн	25,104,194.50		25,104,194.50
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>693,807,475.69</b>		<b>693,807,475.69</b>

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА


**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

#### 5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	687,482,395.25	698,034,468.57
ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
Бусад татвар, төлбөр, хураамж	0.00	0.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,224,738.47	64,577,096.19
Нийтлэг татварын бус орлого	91,837,533.19	62,209,072.48
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	594,257,656.78	633,457,372.37
Улсын төвлөрсөн төсвөөс	412,719,294.80	425,556,564.63
Нэмэлт санхүүжилтийн орлого	13,023,155.80	16,812,253.11
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,895,311.00	2,059,613.58
Төсвийн захирагчдаас	0.00	0.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	166,619,895.18	189,028,941.06
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	568,613,052.37	617,432,113.10
УРСГАЛ ЗАРДАЛ	568,613,052.37	617,432,113.10
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	427,895,773.67	464,678,440.35
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,425,259.90	219,598,327.03
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,698,663.46	24,089,985.08
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,795,736.27	28,032,877.13
Хангамж, бараа материалын зардал	9,566,650.47	10,521,767.48
Нормативт зардал	103,465,416.26	116,048,967.35
Эд хогшил, урсгал засварын зардал	4,160,380.56	5,030,878.54
Томилолт, зочны зардал	1,444,455.37	2,244,041.75
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,188,199.17	7,677,464.50
Бараа үйлчилгээний бусад зардал	35,151,012.21	51,434,131.48
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	140,697,548.35	152,753,672.75
Засгийн газрын урсгал шилжүүлэг	106,699,392.70	109,067,098.35
Бусад урсгал шилжүүлэг	29,960,845.57	38,186,141.99
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,037,310.08	5,500,432.41
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	0.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	118,869,342.89	80,602,355.46
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	119,780,711.75	78,708,008.58
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	119,780,711.75	78,708,008.58
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-119,780,711.75	-78,708,008.58
Бусад эх үүсвэр	541,842.00	129,572.38
Санхүүгийн үйл ажиллагааны зардал	4,753.33	316,879.74
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	537,088.67	-187,307.36
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-374,280.19	1,707,039.52
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,617,806.20	8,243,526.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,243,526.00	9,950,565.53





## 5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	694,714,519.10	674,392,253.75	20,322,265.35	97.07
УРСГАЛ ЗАРДАЛ	609,068,312.80	588,261,333.12	20,806,979.68	96.58
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	460,895,929.70	443,871,714.35	17,024,215.35	96.31
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,653,750.00	215,860,240.80	1,793,509.20	99.18
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,157,649.70	24,004,448.24	153,201.46	99.37
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,367,409.50	27,585,596.13	781,813.37	97.24
Хангамж, бараа материалын зардал	9,173,006.40	8,952,835.25	220,171.15	97.6
Нормативт зардал	111,611,986.30	110,495,763.85	1,116,222.45	99
Эд хогшил, урсгал засварын зардал	5,234,911.90	5,248,874.82	-13,962.92	100.3
Томилолт, зочны зардал	1,009,146.60	726,962.54	282,184.06	72.04
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,928,141.40	5,434,883.14	493,258.26	91.68
Бараа үйлчилгээний бусад зардал	57,759,927.90	45,562,109.59	12,197,818.31	78.88
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	148,172,383.10	144,389,618.77	3,782,764.33	97.45
Засгийн газрын урсгал шилжүүлэг	109,508,371.90	109,058,783.20	449,588.70	99.59
Засгийн газрын дотоод шилжүүлэг	109,474,019.50	109,024,430.80	449,588.70	99.59
Засгийн газрын гадаад шилжүүлэг	34,352.40	34,352.40	0.00	100
Бусад урсгал шилжүүлэг	38,664,011.20	35,330,835.57	3,333,175.63	91.38
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	85,646,206.30	86,130,920.63	-484,714.33	100.6
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	0.00	0.00	0.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	694,714,519.10	675,216,574.65	19,497,944.45	97.19
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	442,231,868.30	435,061,543.99	7,170,324.31	98.38
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	188,396,487.50	187,605,414.05	791,073.45	99.58
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	52,832,889.50	50,604,741.78	2,228,147.72	95.78
БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	3,421,975.29	-3,421,975.29	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	4,246,296.19	-4,246,296.19	0.00

